

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.НАРАНТУЯАГИЙН
2017 ОНД ХИЙХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

2017-11-20

Д/д	Гүйцэтгэх ажил үйлчилгээ	Хүрэх түвшин	Хэрэгжилт
1	2017 оны хүрээгээр ирсэн ҮСХороонд мэдээлэгдэж буй мэдээний үнэн бодит байдалд хяналт хийнэ.	Батлагдсан маягтаар аж ахуйн нэгж байгууллага, сумдаас ирсэн мэдээ тайланг анхан шатны баримттай тулгах, заавар зөвлөгөө өгнө.	<p>2017 оны улсын байцаагчийн хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэлтсийн даргын баталсан 2017 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02 тоот, 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 05 тоот удирдамжуудаар 2017 оны Үндэсний статистикийн хорооноос хүрээгээр ирсэн Үндэсний статистикийн хороонд мэдээлэгдэж буй мэдээний үнэн бодит байдалд “Статистикийн байгууллагын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрэм”, “Статистикийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулиудыг удирдлага болгон хэлтсийн ажилтнуудын хариуцан гаргадаг мэдээ тайланд хяналт шалгалт хийв.</p> <p>Хяналт шалгалтанд АҮ, ХО, ББӨ, Т-1, ҮСҮ-1, ХСҮ-1, ШХҮ-1, ХУ-1Б, ХУ-1, МТС-1, НБХҮ-1, АЖ-1а, СХ-1, ТББ-1, МЭ-1, ЗГ-1А мэдээнүүдийг хамруулж програмын тулгалт хийхэд давхардсан тоогоор 77 аж ахуй нэгжээс 221 мэдээ ирүүлснээс 81 мэдээ алдаатай ирснийг илрүүлэн засварлуулж, ахлах мэргэжилтэн, гэрээт ажилтан нарт хугацаатай албан шаардлага хүргүүлж зөрчлийг арилгуулсан.</p> <p>Зөрчил илэрсэн мэдээг төрлөөр харуулбал: -АҮ мэдээнд 10 аанб хамрагддаг бөгөөд эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор 92 мэдээ ирүүлснээс 43 нь алдаатай - ХО мэдээнд 4 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 12 мэдээ ирүүлснээс 11 нь алдаатай - Т-1 мэдээнд 1 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 3 мэдээ ирүүлснээс 1 нь алдаатай -ШХИУ-1 мэдээнд 1 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 3 мэдээ ирүүлснээс 1 нь алдаатай -ХУ-1Б мэдээнд 4 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 12 мэдээ ирүүлснээс 3 нь алдаатай -ХУ-1 мэдээнд 13 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 39 мэдээ ирүүлснээс 5 нь алдаатай -МТС-1 мэдээнд 6 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын</p>

			<p>байдлаар 5 аж ахуйн нэгж байгууллага нь үйл ажиллагаа явуулаагүй давхардсан тоогоор 3 мэдээ ирүүлснээс 1 нь алдаатай -НБХУ-1 мэдээнд 4 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар 3 аж ахуйн нэгж байгууллага нь үйл ажиллагаа явуулаагүй давхардсан тоогоор 3 мэдээ ирүүлснээс 1 нь алдаатай -АЖ-1А мэдээнд 1 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 3 мэдээ ирүүлснээс 1 нь алдаатай -СХ-1 мэдээнд 3 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 9 мэдээ ирүүлснээс 3 нь алдаатай -ТББ-1 мэдээнд 8 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 24 мэдээ ирүүлснээс 6 нь алдаатай -МЭ-1 мэдээнд 8 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 24 мэдээ ирүүлснээс 3 нь алдаатай -ЗГ-1А мэдээнд 14 аанб хамрагддаг бөгөөд 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 42 мэдээ ирүүлснээс 8 нь алдаатай байв.</p> <p>Дээрхи мэдээг ирүүлсэн холбогдох ажилтан, албан хаагч нарт дахин зөрчлийг давтахгүй байхыг анхааруулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.</p>
2	<p>Сумдын статистик мэдээ хариуцсан төрийн сангийн ажилтан, багийн Засаг дарга нарын мэдээ тайлан гаргалт, явцад хяналт хийнэ</p>	<p>Мэдээлэгч байгууллагаас статистикийн мэдээ тайланг үнэн зөв, графикт хугацаанд нь авч хэвшсэн талаар хяналт хийж, заавар зөвлөгөө өгнө.</p>	<p>2017 оны улсын байцаагчийн хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэлтсийн даргын баталсан 2017 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01 тоот удирдамжаар Шивээговь сумын ЗДТГазрын үйл ажиллагаанд, 2017 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 03 тоот удирдамжаар Баянтал сумын ЗДТГазрын үйл ажиллагаанд “Статистикийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулиудыг удирдлага болгон сум, багийн Засаг дарга нарын “Статистикийн тухай” хуулийг хэрэгжүүлж буй байдалд, статистик мэдээ хариуцан гаргадаг ажилтнууд болон багийн Засаг дарга нарын мэдээ тайлан гаргалт, маягтын нөхөлтөнд, ХАӨМСангийн баяжилт, чанарт тус тус хяналт шалгалт хийв.</p> <p>Шивээговь суманд дараах зөрчил дутагдлууд илэрсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн тайлан хүснэгтэд байгаа алдааны протокол засагдаагүй, мөн хяналт шалгалт хийх явцад тодорхойлолт хүссэн иргэний мэдээллийг мэдээллийн сантай тулгахад зөрүүтэй байгаа нь “Статистикийн тухай” хуулийн 9.6 дахь заалт 2. Иргэн албан тодорхойлолт хүсэхэд нь биеийн байцаалтыг нь

			<p>шалгахгүйгээр өрх ам, бүлийн тодорхойлолт, малын А дансны тодорхойлолтуудыг гарган өгч байгаа нь “Хувь хүний нууцын тухай” хуулийн 5.4 дэхь заалтуудыг тус тус зөрчсөн.</p> <p>Баянтал суманд дараах зөрчил дутагдлууд илэрсэн. Үүнд:</p> <p>Мал эмнэлэг, үржлийн тасаг дээр:</p> <ol style="list-style-type: none"> 3. “Статистикийн тухай” хуультай танилцаагүй байгаа нь Статистикийн тухай хуулийн 4.3 заалт 4. ХАА-1 мэдээний 7,8 дугаар сарын мэдээ дутуу байгаа нь Статистикийн тухай хуулийн 4.3, 9.6 дахь заалт 5. ХАА-2 мэдээний 7,8 дугаар сарын мэдээ дутуу байгаа нь Статистикийн тухай хуулийн 4.3, 9.6 дахь заалт 6. ХАА-3 мэдээний 8 дугаар сарын мэдээ дутуу байгаа нь Статистикийн тухай хуулийн 4.3, 9.6 дахь заалт 7. ХАА-6 мэдээ баталгаажуулалтгүй байгаа нь Статистикийн тухай хуулийн 4.3 дахь заалт 8. ХАА-8 мэдээний 8 дугаар сарын мэдээг гаргахдаа анхан шатны бүртгэл хөтлөөгүй байгаа нь Статистикийн тухай хуулийн 9.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн. <p>1-р багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Н.Мөнгөнцэцэг дээр:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Статистикийн тухай” хууль, “Хувь хүний нууцын” тухай хуулиудтай танилцаагүй байгаа нь Статистикийн тухай хуулийн 4.3, 18, 21 дэхь заалт 2. НС-2 хагас жилийн мэдээний орон гэргүй иргэдийн судалгаа байхгүй байгаа нь Статистикийн тухай хуулийн 9.5 дахь заалт 3. Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас санамсаргүй байдлаар 1 өрхийн мэдээллийг тулгаж үзэхэд 6 үзүүлэлтийн мэдээлэл зөрүүтэй байгаа нь нь “Статистикийн тухай” хуулийн 4.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн. <p>2-р багийн Засаг дарга Б.Энхтөр дээр:</p> <ol style="list-style-type: none"> 1. Хүн ам, өрхийн мэдээллийн сангаас санамсаргүй байдлаар 1 өрхийн мэдээллийг тулгаж үзэхэд 9 үзүүлэлтийн мэдээлэл зөрүүтэй байгаа нь нь “Статистикийн тухай” хуулийн 4.3 дахь заалтыг зөрчсөн. <p>Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, заавар зөвөлгөө өгч ажилласан.</p>
3	Дагаж мөрдвөл зохих хууль тогтоомж, зарлиг, дүрэм,	Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн	Байгууллагын вэб хуудсанд 1.Хууль эрх зүй, 2.Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам гэсэн дэд цэсийг

	<p>журмын талаар сурталчилгаа хийнэ.</p>	<p>зарлиг, ҮСХорооноос гаргасан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт, норм, нормативыг дагаж мөрдөх талаар сурталчилан, заавар зөвөлгөө өгнө.</p>	<p>үүсгэж холбогдох мэдээллийг байршуулан сурталчилсан. Хууль эрх зүй цэсэнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол улсын үндсэн хууль 2. Төрийн нууцын тухай хууль 3. Хувь хүний нууцын тухай хууль 4. Байгууллагын нууцын тухай хууль 5. Статитсикийн тухай хууль 6. Архивын тухай хууль 7. Хөдөлмөрийн тухай хууль 8. Төрийн албаны тухай хууль 9. Авлигын эсрэг хууль 10. Хүн ам, орон сууцны тооллогын тухай 11. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль 12. Зөрчлийн тухай хууль <p>Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж буй дүрэм, журам цэсэнд</p> <ol style="list-style-type: none"> 1. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм 2. Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх 3. Төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах 4. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам 5. Менежерийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх 6. Менежерийн үр дүнгийн гэрээ байгуулах 7. Менежерийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам 8. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх 9. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ байгуулах 10. Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам 11. Үндэсний статистикийн хорооны нууцын журам 12. Статистикийн байгууллагын ажилтны
--	--	--	---

			<p>мэргэжлийн ёс зүйн дүрэм</p> <p>13. Үндэсний статистикийн салбарын шагналын ерөнхий журам</p> <p>14. Үндэсний статистикийн хорооны зөвлөлийн үйл ажиллагааны журам</p> <p>15. Нийслэл, аймгийн статистикийн газар, хэлтсийн жилийн ажлын үр дүнг үнэлэх журмыг шинэчлэн батлах тухай</p> <p>16. Үндэсний статистикийн хорооны хөдөлмөрийн дотоод журам</p> <p>Хэлтсийн цахим хуудас болон фэсбүүк хаягаар Статистикийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль зэргийг таниулснаас гадна дотоод болон гадагшаа чиглэсэн сургалтуудаараа сурталчилсан.</p> <p>Мөн фэсбүүк хаягт Багийн засаг дарга нар нэртэй групп үүсгэн Говьсүмбэр аймгийн сум, багийн Засаг дарга нар, багийн нийгмийн ажилтнууд, статистик хариуцсан төрийн сангийн мэргэжилтнүүд зэрэг ажилтнуудыг нэгтгэн үйл ажиллагаандаа ашиглаж буй хууль, дүрэм, бусад ажил үүрэгтэй холбоотой шинэ мэдээ, мэдээллийг тухай бүрт нь байршуулан сурталчилж байна.</p>
4	<p>Аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллэж буй албан ёсны статистик мэдээ, тайлангийн үнэн бодит байдалд хяналт хийнэ.</p>	<p>Статистикийн мэдээ тайланг үнэн зөв, графикт хугацаанд нь гаргаж хэвшсэн талаар төлөвлөгөөт хяналтыг 3-5 аж ахуйн нэгж байгууллагад хийнэ.</p>	<p>2017 оны улсын байцаагчийн хяналт, шалгалт хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэлтсийн даргын баталсан 2017-08-14 өдрийн 01 тоот удирдамжаар Шивээговь сумын 1-р багт байрлах “Шивээ сервис” ХХК-ны, 2017-09-28 өдрийн 04 тоот удирдамжаар Баянтал сумын 1-р багт байрлах “Чойр хайрхан” ХХК-ны үйл ажиллагаанд тус тус “Статистикийн тухай хууль”, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулиудыг удирдлага болгон Статистикийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заагдсан “Статистикийн мэдээлэгч, хэрэглэгчийн эрх, үүрэг”-ийн дагуу анхдагч бүртгэл хөтөлдөг эсэх, статистикийн хэлтэст хүргүүлсэн цаасан мэдээлэл бодитой эсэхэд хяналт хийлээ.</p> <p>“Шивээ сервис” ХХК-нд дараах зөрчил дутагдлууд илэрсэн.</p> <ol style="list-style-type: none"> 1. АҮ-1 мэдээ гаргахдаа анхан шатны бүртгэл хөтлөөгүй нь Статистикийн тухай хуулийн 9.5 дахь заалт 2. АҮ-1 мэдээг хариуцан гаргадаг ажилтан байхгүй, статистикийн мэдээг удаа дараа хоцроосон, гарын үсгийн тайлалгүй, гаргасан огноо тавьж баталгаажуулаагүй нь

			<p>Статистикийн тухай хуулийн 9.6 дахь заалт</p> <p>3. АУ-1 мэдээг тамга тэмдэг дарж баталгаажуулан цаасаар ирүүлдэггүй нь Статистикийн тухай хуулийн 9.9 дэхь заалтуудыг тус тус зөрчсөн</p> <p>Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, заавар зөвөлгөө өгч ажилласан.</p> <p>“Чойр хайрхан” ХХК-ны хувьд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр Баянтал суманд байршдаг. Статистикийн хэлтэст мэдээ өгдөг нягтлан бодогч нь болон оффис нь УБ хотод байдаг тул үйлдвэрт ашиглагдаж буй ноосны биет хэмжээг статистикийн хэлтэст ирүүлж буй биет хэмжээтэй баримтаар нь тулгаж үзэхэд таарч байв. Статистикийн хэлтэст ирүүлдэг мэдээний анхан шатны бүртгэл нь Улаанбаатар хот дахь төв оффис, нягтлан бодогчид нь байдаг тул хяналт шалгалтыг дуусгаж заавар зөвөлгөө өгч ажилласан.</p>

ТАЙЛАН БИЧСЭН:

СТАТИСТИКИЙН УЛСЫН БАЙЦААГЧ



Б.НАРАНТУЯА